



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.02.20 № 01/02

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Нийгмийн хэв журам хамгаалах газрын 2012 оны санхүүгийн тайланд аудит хийлээ.

Тус газрын 2012 оны хөрөнгийн тооллогоор 7,848,000 төгрөгийн дансны үнэтэй 379 толгой / адуу-3, хонь-338, ямаа-38/ малыг байгаагаар тоолсон боловч бодит байдалд мал байхгүй, бүгдийг худалдан борлуулсан гэсэн боловч орлого нь дансанд орж ирээгүй зөрчил илэрлээ.

Аудитын хугацаанд малын зарлагын гүйлгээний талаар тодруулга хийж өгөөгүй бөгөөд малын худалдан борлуулсан атал мал байгаагаар тоолж бүртгэлээс хасаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих ...” гэж заасныг үндэслэн **АКТ ТОГТООХ НЬ:**

1. Малын дансны үнэ 7,848,000 төгрөг болон худалдан борлуулсан үнийн зөрүүг Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Улсын төсвийн орлогын 900000601 дугаар дансанд 2013 оны 4 дүгээр сарын 01-ны дотор төвлөрүүлэх,
2. Малын зарлагын гүйлгээтэй холбоотой баримт материалыг аудитын байгууллагаар шалгуулах,
3. Тогтоосон актын төлбөрийг барагдуулах ажлыг Нийгмийн хэв журам хамгаалах газрын Аж ахуйн дарга Л.Баттулга, ахлах нягтлан бодогч Д.Аавхүү нарт хариуцуулав,
4. Актын биелэлтийг гаргаж, 2013 оны 4 дүгээр сарын 30-ний дотор ҮАГ-т ирүүлэх.

АКТЫГ

ТОГТООСОН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

Л.ОДГЭРЭЛ

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

НХЖХГ-ЫН АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

АЖ АХУЙН ДАРГА

Д.ААВХҮҮ

Л.БАТТУЛГА

070003